

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 08 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-13

1.Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай	5-9
2.Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл	9-13

Монгол Улсын Их Хурлын “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 07 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Б.Бат-Эрдэнэ, Ш.Бямбасүрэн, Д.Пүрэвдаваа, Ө.Шижир.

Нэг.Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Онончимэг, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, мөн газрын ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8-д “Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно. Түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.” гэж заасны дагуу Түр хорооны даргад анх түр хороог байгуулах саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалыг томилон ажиллуулах саналтай байгааг танилцуулав.

С.Зулпхар: “Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалыг томилъё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	0
Бүгд	6

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Түр хорооны даргыг томилох тухай Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

С.Зулпхар: Түр хорооны даргыг томилох тухай Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	0
Бүгд	6

100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хорооны даргаар томилогдсон Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танд баяр хүргэн, ажлын амжилт хүсэж, хуралдаан даргалагчийн суудалд урьж суулгав./14:18/

Хянан шалгах түр хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хуралдааныг үргэлжлүүлэн даргалав.

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал түр хорооны хэрэгжүүлэх чиг үүрэг болон “Ажлын алба байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжийг танилцуулав.

Уг асуудлыг 14 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Онончимэг, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, мөн газрын ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн нар байлцав.

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Б.Баярбаатар, О.Батнайрамдал нар үг хэлэв.

О.Батнайрамдал: Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдийн саналыг тусган баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	6
Татгалзсан	0
Бүгд	6

100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Түр хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 14 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ОЮУТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН
АШИГЛАЛТАД МОНГОЛ УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ
ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ” ҮҮРЭГ БҮХИЙ ХЯНАН ШАЛГАХ
ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Зулпхар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая аа. Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 62 дугаар тогтоолоор байгуулагдсан Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Түр хорооны хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Ганзориг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар ирсэн байна аа. Ирц ингээд хуулийн дагуу ирц бүрдсэн байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Нэгдүгээрт, Хянан шалгах түр хорооны даргыг сонгох.

Хоёрдугаарт, нотлох баримт гаргуулах тухай асуудал байгаа юм.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад түр хорооны гишүүдээс санал байна уу? За санал байхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8-д түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно.

Түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж заасан байна. Ингээд түр хорооны даргад анх энэхүү одоо түр хороог байгуулах саналыг гаргасан Отгоншарын Батнайрамдал гишүүнийг томилох томилон ажиллуулах ийм саналтай байна.

Та бүхэнд мэдээж хэрэг бас энэ саяын одоо хуулийн өөрчлөлтийг бас танилцуулсан. Одоо бид бол хуулийн дагуу болбол түр хорооны даргад томилогдохоор санал болгож байгаа Батнайрамдал гишүүнээс асуулт асуух учиртай. Батнайрамдал гишүүн та энэ саналыг зөвшөөрч байна уу? За санал байхгүй. Батнайрамдал гишүүн одоо хуулийн дагуу санал гаргасны хувьд бол одоо түр хороог даргалах тухай саналыг бид тавьж байна. Одоо энийг хүлээж авч байгаа юм байна аа.

Одоо санал хураалтдаа оръё. Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх хянан шалгах Түр хорооны даргад Отгоншарын Батнайрамдалыг томилъё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. Саяын одоо жишээ нь томъёоллын дагуу санал хураалт явуулъя.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад оролцсон 6 гишүүний 6 нь дэмжиж, 100 хувийн саналаар Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдалыг Түр хорооны даргаар томилох ийм санал дэмжигдсэн байна аа.

Одоо та бүхэнд Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулъя аа, уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тогтоол. 2025 оны 8 дугаар сарын 12-ны өдөр. Дугаар номер 1. Улаанбаатар хот.

Түр хорооны даргыг томилох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 54.2 дахь хэсэг, Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох.

1.Оюутолгой бүлэг ордыг ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдалыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн Зулпхар гэсэн байна аа.

Жаргалан гишүүн асуулт байна тодруулах зүйл.

Б.Жаргалан: Сая хаврын чуулганаар Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт орсон байгаа. Түүнтэйгээр бол түүнтэй холбоотойгоор болохлоор энэ Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох процесс бас өөрчлөгдсөн байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор яг энэ процесст яг энэ шинэчилсэн хуулийн зохицуулалтын дагуу явж байгаа эсэх тал дээр би бас энэ Их Хурлын Тамгын газраас лавламаар байна. Яагаад вэ гэхлээр энэ анх удаа яг ийм шинэчилсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу бид түр хороог байгуулж, даргыг нь сонгож байгаа ийм процесс болж байгаа. Тэгэхээр энэ бол цаашид бас жишиг болох учраас яг нөгөө тодорхой заалтуудыг нь хэлээд манай одоо нөгөө ажлын хэсгийнхэнд Тамгын газрын ажилтнууд бид хэд яах вэ энэ нөгөө Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг батлах энэ зүйлүүдийг хараад байна л даа.

Тэгэхээр манай энэ түр хорооны хувьд болохлоор бас нэг ийм процессын хувьд 2 өөр зүйл хийгдчихсэн байгаа. Яаж байна вэ гэхлээр түр хорооны

бүрэлдэхүүн батлах Их Хурлын даргын захирамж болохлоор хуулийн өөрчлөлтөөс өмнө батлагдчихсан. Тэгэнгүүтээ одоо болохлоор нөгөө даргыг нь сонгох бөгөөд одоо бусад цаашдын асуудал нь болохлоор нөгөө шинэ хуулийн дагуу явж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ бас нэлээн хянамгай байхгүй бол тэгэхээр би энэ нөгөө Тамгын газраас энэ тогтоол батлахаас өмнө та хэд маань нэг шинэ хуулийн өөрчлөлттэй холбоотой нөгөө зохицуулалтуудыг нь хэлээд өгөөч. Эсвэл Баярбаатар дарга нөгөө ажлын хэсэг ахалж байсан учраас тиймээ.

С.Зулпхар: За Жаргалан гишүүн их чухал асуулт бас хөндөж байна. Биднүүс хуульд өөрчлөлт оруулсан, энэ өөрчлөлт оруулсан хуулийн дагуу өнөөдрийн хуралдаан явагдаж байна уу гэдэгтэй холбоотой тайлбар сонсьё гэж байна. Тухайн үед одоо энэ хуулийн өөрчлөлттэй холбоотой ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар жишээ нь ахалж байсан. Баярбаатар гишүүнээс бас тайлбар сонсьё.

Б.Баярбаатар: Жаргалан гишүүний асуулт их зөв асуулт байгаа юмаа. Энэ яг нөгөө хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдах цаг үеийг ингээд дамнуулаад түр хороо маань бол хууль батлагдахаас өмнө байгуулагдаад, одоо өнөөдөр даргаа сонгож байгаа процесс нь бол хууль батлагдаад, хэрэгжээд эхэлчихсэний дараа бол дарга сонгож байгаа. Тэгэхдээ энэ бол яг анх төсөл орж ирсэн санал дээрээсээ бол ажлын хэсгийн явцад бол өөрчлөгдөөд, Цогтгэрэл гишүүний оруулж ирсэн санал өөрчлөгдөөд, 33.8 дээр түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно.

Түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно оо гээд ингээд хуульчлаад одоо яг эцсийн хувилбар нь ёсчилсон хувилбар нь энэ байж байгаа. Анх бол орж ирсэн томьёолол нь Жаргалан гишүүн нөгөө Цогтгэрэл даргынх дээр бол нөгөө цөөнхийн төлөөллөөс гэж байсныг бол ажлын хэсгийн явцын дунд өөрчлөгдөөд ингээд санаачилсан гэдгээрээ бол ороод явчихсан байж байгаа. Тэгэхээр энэ өнөөдөр Отгоншарын Батнайрамдал гишүүн бол энэ Оюутолгойтой холбоотой энэ түр хороог байгуулах саналыг Их Хурлын даргад санаачилж тавьсан Улсын Их Хурлын гишүүний хувьд бид нар энэ шинэ мөрдөгдөж байгаа энэ дүрмийн заалтаараа яг ингээд анх санаачилсан гишүүн нь ингээд даргаар сонгогдож байна.

С.Зулпхар: Баярбаатар гишүүнд баярлалаа. Жаргалан гишүүн нэмж тодруулах зүйл байна уу танд. Жаргалан гишүүн нэмж тодруулах зүйл байна уу? Тодруулах зүйл байхгүй юм байна. За сая Жаргалан гишүүний асуулт, Баярбаатар гишүүний хариулт болбол бид хуульд орсон өөрчлөлтийн дагуу буюу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8-д орсон өөрчлөлтийн дагуу өнөөдрийн хуралдааныг зохион байгуулж байгаа. Тэгэхлээр яг одоо хуралдаан болбол хуулийн дагуу явж байгаа юм байна. Бас энэ талаар тодруулга авч бас тодорхой хариултуудыг бас өгөгдлөө.

Одоо бид сая тогтоолын төслийг та бүхэнд танилцуулсан. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад бид бас санал хураалт явуулах ёстой. Санал хураалтад бэлдье. Санал хураалт явуулъя.

Тогтоолын төслийг 6 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар батлагдлаа.

Ингээд Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Хянан шалгах түр хорооны даргаар томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал танд баяр хүргэж, ажлын амжилт хүсье. Таныг хуралдааны даргалагчийн суудалд урьж байна аа.

О.Батнайрамдал: Хянан шалгах түр хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Итгэл хүлээлгэж Түр хорооны даргаар сонгосонд та бүхэндээ маш их баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.7-гийн хэсэгт түр хорооны дараах бас чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж бас заасан байгаа. Та бүхэнд энийг бас уншаад танилцуулъя.

1 дүгээрт Түр хорооны үйл ажиллагааг зохион байгуулах, уялдуулан зохицуулах.

2 дугаарт Түр хорооны хуралдаан, сонсголыг даргалах, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах.

3 дугаарт Түр хорооны хуралдаан сонсголын бэлтгэлийг хангуулах, шийдвэрийг баталгаажуулах, түүний биелэлтэд хяналт тавих гэж байгаа.

4 дүгээрт Түр хорооноос эрх олгосны дагуу нотлох баримтыг шинжлэн судлах сонсголд нэмж дуудах гэрчийн нэрсийг сонсгол болохоос 7-гоос доошгүй хоногийн өмнө шийдвэрлэх.

Түр хороог төлөөлөх Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан бусад үүрэг түр хорооны даргын үндсэн чиг үүрэгт багтаж байгаа.

Мөн түр хорооны даргын санаачилгаар эсхүл түүний нийт гишүүний 4-ний 1-ээс доошгүй шаардсанаар түр хорооны хуралдааныг хуралдуулах бөгөөд хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө түүний хэлэлцэх асуудал, хуралдааны товыг гишүүдэд урьдчилан мэдэгдэнэ ээ гэж мөн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлд бас заасан байгаа.

Ингээд түр хорооны хуралдааны хэлэлцэх бас дараагийн асуудалд орохоосоо өмнө та бүхэнд бас Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжийг бас танилцуулъя.

Хянан шалгах түр хороог бас дэмжиж ажиллахаар Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж Ажлын алба байгуулах тухай бол гарсан байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийг үндэслэн Захирамжлах нь.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 7 сарын 2-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл

ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх ажлын албыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсан байгаа.

Ажлын албаны ахлагч Тамгын газрын Хяналт шалгалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Онончимэг дарга томилогдсон байгаа. Онончимэг дарга. Нарийн бичгийн даргаар Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн референт Гэрэлт-Од, Тамгын газрын Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн Сэргэлэн, 2 нарийн бичигтэй. Мөн гишүүдээр Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Мягмарцэрэн, Тамгын газрын Хуулийн газрын зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Амармөрөн, мөн Тамгын газрын хяналт шалгалтын газрын референт Мөнхтуяа нар бас ажиллаж, үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зохион байгуулалтын бас дэмжлэг үзүүлэхээр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамж гарсан байгааг та бүхэнд бас энэхүү завшааныг ашиглаад танилцуулъя.

14:21

О.Батнайрамдал: Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг. Түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй саналаар хянан шалгагчийг томилж, ажлын даалгаврыг батална аа гэсэн.

Мөн 39.4 дэх хэсэгт хянан шалгалтын явцад нотлох баримт гаргуулах, шаардлагатай гэж үзвэл хянан шалгагч энэ хуулийн 37.1-д заасны дагуу тогтоол гаргуулах саналаа түр хороонд оруулна аа гэж заасан байгаа.

Өнөөдрийн хуралдаанаар хянан шалгагчийн ажлын даалгаврыг батлах тухай тогтоолын төслийг хэлэлцэж батална. Тэгээд тогтоолын төслийг та бүхэнд бас тараасан байгаа.

Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? За байхгүй байна. Жаргалан гишүүн. Жаргалан гишүүнээр тасалъя. Жаргалан гишүүний микрофон.

Б.Жаргалан: Түр хорооны хянан шалгагчийн ажлын даалгаврыг бол дөнгөж сая л авч байна л даа. Тэгэхээр энэ ажлын даалгавар одоо энэ түр хорооноос ер нь батлагдах баримт бичгүүдийг бас урьдчилан тараагаад бас үүн дээр нөгөө санал бодол тусгайлсан саналуудаа хэлэх боломжийг бас хангаж ажилламаар байна. Одоо түр хорооны ахлагч маань.

Тэгэхээр өнөөдрийн хувьд бол миний санал болохлоор энэ нөгөө ажлын хэсгийнхээ даалгавартай бид нар танилцаад, энэ дээр бас нэмж. Надаа бол зүгээр ингээд зурвас харахад бол хэтэрхий өргөн хүрээтэй, яг нарийвчилсан зүйлүүд бас нэмж тусгах шаардлагатай харагдаад байна л даа. Тэгэхээр нэг тодорхой бас нэг саналуудаа боловсруулж, нэмж тусгах хугацаагаар хангаж өгнө үү гэж хүсмээр байна.

О.Батнайрамдал: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Саналаа хэлэх үү тиймээ. Баярбаатар дарга бас саналаа хэлье гэж байна. Баярбаатар даргын нэрийг оруулаад микрофон өгөх үү?

Б.Баярбаатар: Тийм анхны хурал болж байна. Даргаа бид нар сонгоод явчхаж байгаа. Ер нь бол энэ түр хороо гэдэг маань бол бид нар нэлээн өндөр түвшинд ажиллах зайлшгүй шаардлага байгаа. Нийгэмд бол нэлээн хүлээлт үүсчихсэн байгаа. Дээр нь энэ яг энэ Оюутолгойтой холбоотой асуудлаар бүр олон жил олны анхаарлын төвд явчихсан. Зөв буруугийн дэнсийг нь тэр болгон иргэдэд зөв зүйтэй ойлгуулж чадаагүй. Одоо үүсээд байгаа нөхцөл байдлын талаар бол иргэд төдийгүй Улсын Их Хурлын гишүүдийн хэмжээнд бүрэн ойлголтгүй л юм явж байгаа асуудал байгаа.

Тэгээд Батнайрамдал дарга энэ дээр онцгой анхаарах ёстой. Бид нар энэ парламентын хяналт гэдэг маань цаашлаад энэ чинь парламентын нэр хүндийн асуудал байж байгаа. Энэ хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг маань 2019 оноос хойш идэвхжиж ажиллаад, өнгөрсөн хугацаанд нүүрс, ногоон автобус, утаа гээд ингээд хэд хэдэн утаа ор луу яалаа, хэд хэдэн сонсголудыг хийсэн байдаг юм Түр хороо байгуулж, тэгээд энэний үр дүн өнөөдөр болбол иргэдэд нэг их тийм айхтар үр дүнтэй болоогүй учраас цаашлаад энэ маань өөрөө энэ парламентын нэр хүндийн асуудалд нөлөөлөөд байх ийм асуудал байгаа юм.

Дараагийн нэг асуудал энэ уул уурхай буюу энэ Оюутолгойтой холбоотой асуудал ер нь ингээд тодорхой түвшинд ингээд яригдаад эхлэхээр бид нар одоо сөрөг зүйлүүдтэй их тулгарна. Ялангуяа хэвлэл мэдээлэл пиарын тал дээр. Одоо манай энэ түр хорооны 11 гишүүн бол одоо бас тодорхой түвшинд судлагдаад л явж байгаа болов уу гэж би бол харж байгаа. Энэ дээр би юу харсан бэ гэхээр анх түр хороо байгуулагдаад хэвлэлийн хурал хийсэн бид нар. Чуулган завсарлаагүй байсан. Чуулганы танхимын үүдэнд маш олон сэтгүүлчид байсан. Тэгтэл тэр хэвлэлийн хурал тэр өдөр ганц нэг сайтаар явснаас явсныг эс тооцвол ер нь 100 хувь бараг цацагдаагүй. Бараг тест хийчихсэн гэхэд болно. Тэгэхээр цаашлаад энэ мэтийн ийм эсэргүүцлүүд нэлээдгүй тулгарах учраас бид нар энэ түр хорооны ажлын төлөвлөгөө, энэ зураглал гэдэг юмаа нэн түрүүнд гаргах зайлшгүй шаардлага байна.

Энэ 11 гишүүндээ гарын авлага бэлдэж өг. Энэ түр хороо ямар эрх, үүргийн дагуу ажиллах юм. Яг энэ ямар хүрээнд ажиллах юм бид нар, ямар эрх байгаа юм бид нарт, юу болох юм, юу болохгүй юм. Мөрдөн шалгах чиг үүргийн хэмжээнд бид нар мөрдөн шалгах гээд байгаа юм уу, эс үгүй бол чиг үүрэг бүхий хууль хяналтын байгууллага нь мөрдөн шалгах юм уу гэдэг нөгөө ийм хүрээгээ эхлээд тогтож авах нь хамгийн 1 дүгээр асуудал болов уу гэж би харж байгаа юм. Яах вэ өнөөдөр бид нар энэ ажлын даалгавраа бол Жаргалан гишүүн ээ батлаад явчихъя.

Цаашдаа бид нар энэ хэлэлцэх асуудлынхаа хувьд бол зарим нь нууцлалтай ч холбоотой асуудал. Одоо жишээлбэл 11 энэ түр хорооны гишүүн өнөөдөр бид нар энэ нууцлалын баталгаан дээр гарын үсэг зурах ёстой. Энэ хаа байна. Одоо энэ мэдээ мэдээлэл задардаггүй байх ёстой. Бидний ярьсан яриа минутын дараа хэвлэл мэдээлэл сайтуудаар зарлагдаад яваад байвал ямар хэрэг байсан юм. Ингэх гэж байгаа, тэгэх гэж байгаа, төлөвлөгөө тэгвэл бид нар энэ асуудал юмнууд дээрээ ингээд нэг ийм яг төлөвлөгөө дарааллаа ингээд нэг нухацтай гаргаж байгаад нэг ийм ойрхон хурал ер нь зарлах нь зөв болов уу гэж би санал шүү тийм.

О.Батнайрамдал: Гишүүддээ баярлалаа. Тэгэхээр 2024 оны шинэ парламент бүрдсэнээс хойших хамгийн анхны бас Хянан шалгах түр хороо, мөн одоо Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн бас шинэчлэлтэй холбоотойгоор анхны ингээд Хянан шалгах түр хороо ингээд байгуулагдаад Оюутолгой асуудал дээр байгуулагдаад явж байгаа. Тэгэхээр Баярбаатар даргын хэлж байгаа үнэн л дээ. Тэгээд бид нар улам мэдээлэл нь гарсан боловч олон асуудалтай ер нь цаашдаа тулгарах болов уу.

Монгол Улсын эдийн засаг 36 тэрбум долларын эдийн засаг. За Оюутолгой төсөл бол өөрөө 26 тэрбум долларын төсөл, Монгол Улсын хамгийн том эдийн засгийн төсөл. Тэгэхээр энэ дээр бид нар төр одоо Улсын Их Хурлын тогтоол дээр бол хил хязгаараа тогтоож ер нь Улсын Их Хурлын тогтоол дээрээ тогтоож орж ирсэн яг энэнийхээ хүрээнд бид нар үйл ажиллагаагаа одоо хуулийн хүрээнд бас ингээд явуулах боломжтой. Тэгэхээр ажлын төлөвлөгөө бас цаашаагаа хэрхэн анхны одоо Хянан шалгах түр хороо хэрхэн ажиллах вэ гээд чухал асуудлуудыг хөндөж байна. Тэгэхээр дараагийн хурлаас бид нар одоо ажлын төлөвлөгөөний драфт бол гарсан байгаа. Гишүүддээ бүгдээрээ мэдээллээр бол хангаж явна. Ажлын төлөвлөгөөний драфт гэх мэтчилэн бүх мэдээллийг өгч бид нар дараа дараагийн хурал дээрээ бол эднийгээ ярилцаад явна аа.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо байгуулагдахдаа бас 6 сарын хугацаатайгаар байгуулагддаг. Яах вэ тэгээд яг чуулган завсарласантай бас холбоотой яг ингээд таарч таарсан. Тийм болохоор бид нар цаг хугацааны хувьд бол бас нэлээн шахуу ажиллана. Тэгэхээр тийм болохоор өнөөдрийн эхний хурал дээрээ бид нар яг одоо Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн одоо яг 9 дүгээр хэсэгт тиймээ 7 дугаар бүлэг дээр Хянан шалгах түр хороог хэрхэн байгуулах талаар бол маш ойлгомжтой ингээд бидний эрх зүйн байдлыг бол тодорхойлж өгсөн байдаг. Тэгэхээр бид нар бол хуулийнхаа хүрээнд хянан шалгагч, шинжээч гэсэн 2 албан тушаалд 2 төрлийн албан тушаалаар бол бид нар томилж, цаашдаа нотлох баримт цуглуулах, нотлох баримт дээр санал дүгнэлт боловсруулах ажлыг бол хийж явна.

Тийм учраас энэ ажлаа цаг хугацаа алдалгүй явуулахын тулд бид нар ажлын даалгавраа өнөөдөр баталж байж дараагийн хурлууд дээрээсээ хянан шалгагчаа томилох тэр эрх одоо эрх зүйн хувьд ингээд нээгдэх юм. Тийм болохоор та бүхэнд саналуудаа бас бичгээр өгчих. Тэгээд өнөөдөртөө эхний хурал дээрээ Хянан шалгах түр хорооныхоо одоо хянан шалгагчийнхаа ажлын даалгавраа ерөнхий даалгавраа батлаад явъя гэсэн саналтай байна аа. Жаргалан гишүүн горимын санал.

Б.Жаргалан: Миний ойлгож байгаагаар ажлын даалгавар бол бас хянан шалгагчид одоо бид нарын томилох экспертүүдийн экспертүүдэд тавигдах шаардлагатай бас хамт батлагдах ёстой гэж ойлгоод байгаа. Яагаад вэ гэхлээр одоо энэ ажлын даалгавар чинь болохлоор нөгөө хянан шалгагч нарт тавигдах ажлын даалгавар шүү дээ. Тэгэнгүүтээ одоо бид нар хянан шалгагч баг бүрэлдэхүүн нь ямар хүмүүс байх юм, ямар хүмүүсийг экспертээр томилох юм гэдэг шалгуур чинь уул нь энэ ажлын даалгавартайгаа уялдаатай явах ёстой байхгүй юу. Тэгэхээр уул нь бол хар аа. Тэр нөгөө тэр 2 юмаа хамт оруулаад ирвэл бас нэг бодлын илүү ажилд бол дөхөм санагдаж байна. Хэрэв ажлын хэсгийн ахлагч хэрэв одоо түр хорооны дарга хэрэв өнөөдөр ажлын даалгавраа батлаад явъя гэж байгаа бол би бол нөгөө бас түр хорооны гишүүний хувьд саналуудаа тусгах тэр бас нэг юугаа

нээлттэй орхиод тиймээ. Тэгээд дараа нь болохлоор нөгөө экспертүүдэд тавигдах шаардлагууд, экспертүүдийн жагсаалт бас гарах ёстой шүү дээ тиймээ, бид нар тэрийгээ батлах ёстой. Тэр үед нь бол бас энэ саналуудаа тусгаад оруулъя гэсэн бас нэг ийм саналтай байна. Тэгэхээр энийг бас би протоколд тэмдэглүүлэхийг хүслээ.

Тэгээд цаашдаа болохлоор энэ зарим материалуудаа бол нөгөө өмнө нь бас ажлын одоо энэ түр хорооны гишүүддээ урьдчилж бас тарааж өгөөд, тэгээд саналуудыг нь бол цаг тухайд нь бас авч баймаар байна аа. Энийг бас би протоколд хэлмээр байна аа. Тэгээд саяын тэр нөгөө дурдагдсан дэд ажлын хэсгийн бөгөөд одоо Их Хурлын Тамгын газрын баг бүрэлдэхүүний бүрэлдэхүүнтэй холбоотой нарийн бичгийн даргын тогтоолыг бас нөгөө бидэнд илгээж өгнө үү? Ер нь бол одоо энэ Түр хороотой холбоотой байгаа бүх баримт бичиг нөгөө түр хорооны гишүүдэд бас яг ижил төстэй байдлаар ирж баймаар байна.

О.Батнайрамдал: За Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 39 дүгээр зүйл дээр бол Хянан шалгагчийг томилох, мөн хянан шалгагчид тавигдах шаардлагыг бол хуулийн маш ойлгомж хууль дээр бол ойлгомжтой заагаад өгчихсөн байгаа юм.

39.1 дээр бол түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй саналаар хянан шалгагчид ажлын даалгавраа батална аа гээд. Нэг ёсондоо бид нар хуулийн дагуу ажлын даалгавраа баталж байж, ажлын даалгаврын хүрээнд бид нар батална шүү дээ. Хянан шалгагчид тавигдах шаардлагаа ажлын даалгавраа баталж байж ажлын даалгаврын хүрээнд хянан шалгагчаа бид нар нэрсийг нь авна шүү дээ. Жаргалан гишүүн бас чухал асуудлыг хөндөөд байна л даа.

Тэгэхээр бүгдээрээ ажлын даалгавраа гишүүдийн саналуудыг нээлттэй авах журмаар өнөөдрийнхөө ажлын даалгаврыг батлаад явъя. Тэгээд та бүхнийхээ саналыг тусгаад, дараа нь нөгөө ажлын даалгаврын хүрээнд хянан шалгагчаа томилохдоо энэ 2 маань параллелный явах учраас тэр одоо бүх саналуудаа тусгаад, нэг бүрчлэн ярих боломжтой гэж бодож байна аа.

За бүгдээрээ тэгвэл ажлын даалгаврынхаа санал хураалтад бэлдье. Түр хорооны хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай тогтоолын төслийг та бүхэндээ уншиж танилцуулъя.

Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1 дүгээр хэсэг, Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Тогтоох нь:

Оюутолгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хянан шалгалт хийх үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн ажлын даалгаврыг хавсралтаар баталсугай.

2.Ажлын даалгаварт дурдсан нотлох баримтуудыг холбогдох байгууллагуудаас хуулийн шаардлага хангуулан гаргуулан авах, мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах, хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, дүгнэлт тайлангаа сонсголд танилцуулахыг хянан шалгагч нарт үүрэг болгосугай.

Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянан шалгах түр хорооны дарга Батнайрамдалд даалгасугай гэсэн ажлын даалгавар байна.

Тэгээд гишүүдийн дараагийн хурлаар орох санал дараа авах саналуудтай уялдуулаад энэ ажлын даалгавраа баталъя гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя аа. Санал хураалт. Санал хураалтад бэлдье, бэлдчихсэн тиймээ. Би энд ороогүй байсан байна. Санал хураалт.

Тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явах уу.

Санал хураалтад 6 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай тогтоолын төслийг дэмжлээ. Тогтоол батлагдсанд тооцлоо.

Хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье. Хүрэлцэн ирсэн гишүүддээ маш их баярлалаа.

14:37

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ